



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.09.24 № 187
танай _____ ны № _____ т

РАШААНТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Н.МӨНХСАЙХАН ТАНАА

Төрийн аудитын газраас танай байгууллагын
2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах
аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 11,763.7 мянган төгрөгийн 1 албан
шаардлага, 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны
06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн
хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030182

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/139/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenkhamg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 186

танай _____ ны № _____ т

РАШААНТ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Н.МӨНХСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Соёлын тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдаж 2022 оноос мөрдөж эхлэн, эрхлэгч, номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музейн ажилтны нийт 5 орон тоотойгоор сумын хүн амд соёл, урлагийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын XIV.2.3-д 2021-2022 онд дамжуулан хийсэн их засварыг улсын комисс хүлээн авч, соёлын төвийн барилгыг капиталжуулсан нь тайлант хугацааны үр дүнд нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

006020218

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,554,947.00	35,269,447.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	7,940,900.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	7,940,900.82
3121	Төгрөг	-	7,940,900.82
31211	Төрийн сангийн харилцах	-	7,940,900.82
33	АВЛАГА	22,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	22,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	23,532,947.00	27,328,547.00
354	Хангамжийн материал	23,532,947.00	27,328,547.00
35410	Бичиг хэргийн материал	161,900.00	150,000.00
35420	Аж ахуйн материал	-	4,057,000.00
35470	Бусад хангамжийн материал	23,371,047.00	23,121,547.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	562,158,382.64	888,269,657.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	562,158,382.64	888,269,657.63
392	Биет хөрөнгө	559,820,382.66	884,751,657.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	601,998,463.72	933,281,372.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(78,240,139.98)	(111,565,398.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,039,595.70	48,736,214.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,650,468.20)	(9,782,874.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,918,572.60	13,830,708.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,045,098.18)	(3,014,020.86)
39217	Ном	12,799,457.00	13,265,657.00
393	Биет бус хөрөнгө	2,337,999.98	3,517,999.94
39301	Программ хангамж	1,000,000.00	2,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.02)	(750,000.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,588,000.00	1,588,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	585,713,329.64	923,539,105.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,000.00	-
413	Өглөг	22,000.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	22,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	585,691,329.64	923,539,105.45
51	Засгийн газрын хувь оролцоо	585,691,329.64	923,539,105.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	73,625,545.70	73,625,545.70
51101	Өмч:- төрийн	73,625,545.70	73,625,545.70
512	Хуримтлагдсан үр дүн	(179,889,304.30)	158,064,039.83
51210	Өмнөх үеийн үр дүн	(162,866,004.73)	(186,874,421.44)
51220	Тайлант үеийн үр дүн	(17,023,299.57)	344,938,461.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	691,955,088.24	691,849,519.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	585,713,329.64	923,539,105.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	108,163,700.00	487,267,606.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,109,500.00	369,464,506.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,109,500.00	369,464,506.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,109,500.00	369,464,506.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	109,500.00	443,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,000,000.00	369,020,606.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,054,200.00	117,803,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	99,054,200.00	74,329,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	99,054,200.00	74,329,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	42,673,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	42,673,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	125,186,999.57	142,262,644.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,186,999.57	142,262,644.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	123,041,465.57	141,194,533.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,580,902.00	50,644,255.28
210101	Үндсэн цалин	39,825,831.00	38,603,195.28
210102	Нэмэгдэл	7,755,071.00	8,767,734.00
210104	Урамшуулал	-	3,273,326.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,158,343.00	6,330,532.90
210201	Тэтгэврийн даатгал	4,264,008.00	4,304,762.42
210202	Тэтгэмжийн даатгал	486,237.00	506,442.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	375,684.00	405,154.06
210204	Ажилгүйдлийн даатгал	85,247.00	101,288.56
210205	Эрүүл мэндийн даатгал	947,167.00	1,012,885.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,033,700.00	39,900,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,133,700.00	1,014,036.00
210302	Түлш, халаалт	38,900,000.00	38,885,964.00
2104	Хангамж, бараа материалын зардал	333,000.00	712,900.00
210401	Бичиг хэрэг	68,000.00	137,200.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	125,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	617,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	158,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	459,500.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	178,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	178,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,792,000.00	3,330,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,792,000.00	3,330,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,705,520.57	39,481,295.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,582,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,705,520.57	37,898,345.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,145,534.00	1,068,111.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	1,068,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	1,068,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	111.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	111.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,945,534.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,945,534.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,023,299.57)	345,004,961.27
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	66,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	66,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(66,500.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,023,299.57)	344,938,461.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>99,163,700.00</u>	<u>118,247,000.00</u>	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,500.00	443,900.00	
120	Нийтлэг татварын бус орлого	109,500.00	443,900.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	109,500.00	443,900.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	109,500.00	443,900.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,054,200.00	117,803,100.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	99,054,200.00	74,329,600.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	99,054,200.00	74,329,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	800,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	42,673,500.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	42,673,500.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>98,163,700.00</u>	<u>108,159,899.18</u>	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,163,700.00	108,159,899.18	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,018,166.00	107,391,788.18	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,163,123.00	50,565,572.73	
210101	Үндсэн цалин	39,408,052.00	40,627,845.73	
210102	Нэмэгдэл	7,755,071.00	9,263,523.00	
210104	Урамшуулал	-	674,204.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,158,343.00	6,409,215.45	
210201	Тэтгэврийн даатгал	4,264,008.00	4,357,637.76	
210202	Тэтгэмжийн даатгал	486,237.00	512,904.20	
210203	ҮОМШӨ-ний даатгал	375,684.00	410,043.56	
210204	Ажилгүйдлийн даатгал	85,247.00	102,860.53	
210205	Эрүүл мэндийн даатгал	947,167.00	1,025,769.40	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,033,700.00	39,900,000.00	
210301	Гэрэл, цахилгаан	1,133,700.00	1,014,036.00	
210302	Түлш, халаалт	38,900,000.00	38,885,964.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	325,000.00	701,000.00	
210401	Бичиг хэрэг	60,000.00	91,500.00	
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	450,000.00	

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	-
210404	Ном, хэвлэл	-	33,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	125,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	1,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	178,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	178,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,900,000.00	5,938,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	5,938,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,145,534.00	768,111.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	768,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	768,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	111.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	111.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,945,534.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,945,534.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,000,000.00</u>	<u>10,087,100.82</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,000,000.00	2,146,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,000,000.00	2,146,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,000,000.00	2,146,200.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,146,200.00
223001	Бусад хөрөнгө	1,000,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,000,000.00)</u>	<u>(2,146,200.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	7,940,900.82
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,940,900.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,625,545.70	691,955,088.24	(162,866,004.73)	602,714,629.21
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,625,545.70	691,955,088.24	(162,866,004.73)	602,714,629.21
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,023,299.57)	(17,023,299.57)

4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,625,545.70	691,955,088.24	(179,889,304.30)	585,691,329.64
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,625,545.70	691,955,088.24	(179,889,304.30)	585,691,329.64
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(6,985,117.14)	(6,985,117.14)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,625,545.70	691,955,088.24	(186,874,421.44)	578,706,212.50
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(105,568.32)	-	(105,568.32)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	344,938,461.27	344,938,461.27
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,625,545.70	691,849,519.92	158,064,039.83	923,539,105.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	120,353,100.00	109,505,988.18	10,847,111.82	91.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	120,353,100.00	109,039,788.18	11,313,311.82	90.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,585,100.00	108,271,788.18	11,313,311.82	90.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,231,800.00	50,565,572.73	6,666,227.27	88.4
210101	Үндсэн цалин	44,115,800.00	40,627,845.73	3,487,954.27	92.1
210102	Нэмэгдэл	9,258,300.00	9,263,523.00	(5,223.00)	100.1
210104	Урамшуулал	3,857,700.00	674,204.00	3,183,496.00	17.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,154,300.00	6,409,215.45	745,084.55	89.6
210201	Тэтгэврийн даатгал	4,864,500.00	4,357,637.76	506,862.24	89.6
210202	Тэтгэмжийн даатгал	572,600.00	512,904.20	59,695.80	89.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	457,900.00	410,043.56	47,856.44	89.5
210204	Ажилгүйдлийн даатгал	114,700.00	102,860.53	11,839.47	89.7
210205	Эрүүл мэндийн даатгал	1,144,600.00	1,025,769.40	118,830.60	89.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,900,000.00	39,900,000.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	1,014,036.00	(14,036.00)	101.4
210302	Түлш, халаалт	38,900,000.00	38,885,964.00	14,036.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	675,000.00	201,000.00	474,000.00	29.8
210401	Бичиг хэрэг	60,000.00	91,500.00	(31,500.00)	152.5
210402	Тээвэр, шатахуун	450,000.00	450,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	-	75,000.00	-
210404	Ном, хэвлэл	-	(466,200.00)	466,200.00	-!
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	125,700.00	(35,700.00)	139.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,400,000.00	1,400,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	1,100,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00	-	100.0
2107	Томиллолт, зочны зардал	256,000.00	178,000.00	78,000.00	69.5

210702	Дотоод албан томилолт	256,000.00	178,000.00	78,000.00	69.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,618,000.00	7,618,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,618,000.00	7,618,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,350,000.00	2,000,000.00	3,350,000.00	37.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,350,000.00	2,000,000.00	3,350,000.00	37.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	768,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	768,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	466,200.00	(466,200.00)	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	466,200.00	(466,200.00)	-
222001	Тоног төхөөрөмж	-	466,200.00	(466,200.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	120,353,100.00	117,447,000.00	2,906,100.00	97.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	74,329,600.00	74,329,600.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	74,329,600.00	74,329,600.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,673,500.00	42,673,500.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	42,673,500.00	42,673,500.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,350,000.00	443,900.00	2,906,100.00	13.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,350,000.00	443,900.00	2,906,100.00	13.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,940,900.82	(7,940,900.82)	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	4	1	80
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	4	3	1	75
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5	4	1	80
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	4	1	80

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансыг ашиглаагүй болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрхэм зорилгоо “соёлын биет болон биет бус өв уламжлалыг өвлүүлэн түгээж, ардын уламжлал урлагийг орчин үеийн төрөл зүйлтэй хослуулан хөгжүүлж, эх хэл түүх соёлоороо бахархах, үндэсний өвөө өвлөн эзэмших, иргэнийг төлөвшүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэл дэмжин, соёлын боловсролыг дээшлүүлэн хөгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Зорилгоо хэрэгжүүлэхээр соёлын хэрэгцээг эрхэмлэн дээдэлж үнэт зүйлсээс суралцан, өвлөн уламжлан, бүтээж туурвин, зааж сурган түгээн дэлгэрүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Сумын түүх, соёлын өв, түүнийг өвлөн уламжлагч, хүн амын уламжлалт ёс заншил, зан үйл, байгаль цаг уур, бүтээн байгуулалтын онцлогтой холбоотой “Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, байнга баяжуулан, иргэдийн танин мэдэхүй, соёл урлагийн авьяас чадварын түвшнийг дээшлүүлэх үндсэн үйл ажиллагааг номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музейн ажилтан, нягтлан бодогч нийт 5 орон тоотойгоор төрийн үйлчилгээг үзүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Рашаант сумын Соёлын төв нь Соёлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Соёлын яамны бодлогын баримт бичиг батлагдаагүйгээс, Орон нутгийн байгууллагуудын мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна.

Соёлын Байгууллагын даргын баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 337,825.0 мянган төгрөгөөр буюу 57.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	7,940.90	7,940.90
Авлага	22.00	-	(22.00)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	23,532.95	27,328.55	3,795.60
Үндсэн хөрөнгө	562,158.38	888,269.66	326,111.27
Нийт хөрөнгө	585,713.33	923,539.11	337,825.78
Өр төлбөр	22.00	-	(22.00)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	585,691.33	923,539.11	337,847.78
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	585,713.33	923,539.11	337,825.78

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь үндсэн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн оролцоо данснууд өссөн байна.

Бараа материалын данс өссөн шалтгаан нь хөдөлмөр хамгааллын хувцас, хүрэм, албан тасалгааны хувцас, тавиур, гэрлийн пүлт, тайзны хөшиг 4,057.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XIV.2.3-д 2021-2022 онд дамжуулан 332,819.9 мянган төгрөгийн их засварыг улсын комисс хүлээн авч, соёлын төвийн барилгыг капиталжуулан сайжруулалт хийснээр үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 43,673.5 мянга, улсын төсвөөс 93,215.4 мянга, өөрийн орлогоос 1,500.0 мянган төгрөг нийт 138,388.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 18,035.8 мянган төгрөгөөр бууруулж, өөрийн орлогоос 3,350.0 мянга, улсын төсвөөс 74,329.6 мянга, орон нутгийн төсвөөс 42,643.5 мянган төгрөг нийт 120,353.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийг тодотгоогүй байна. 2022 онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 120,353.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 74,329.6 мянга, орон нутгийн төсвөөс 42,673.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 800.0 мянган төгрөгийг аймгийн Соёл, урлагийн газраас, 443.9 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 109,505.9 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 10,847.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Соёл урлагийн газрын санхүүжилтийг номын сангийн номын баяжилтад 500.0 мянга, тохижилтод 300.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
	Код	Арга хэмжээ				
Нийт дүн			120,353.1	109,506.1	10,847.0	91.0
1	70702	80101	70,561.6	61,820.7	8,740.9	87.6
2		80214	3,000.0	3,000.0	-	100.0
3		80802	768.0	768.0	-	100.0
4		83603	3,350.0	1,243.9	2,106.1	37.1
5		80111	40,200.0	40,200.0	-	100.0
6		80112	2,473.5	2,473.5	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Рашаант сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 120.35361 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,805.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,353.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс бүх мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 13 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	1,251.9	2	1,251.9	100.0
Зөвлөмж	1	772.2	1	772.2	100.0
Нийт дүн	3	2,024.1	3	2,024.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,948.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 9,948.1 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 1,815.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 957.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 858.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогчийг цалингийн ангилал /ТҮ-8/-аар тооцож улирал тутамд 40 хувиар цалинжуулж, хэмнэгдсэн цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “*батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох*”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 83 дугаар тушаалаар баталсан “*сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм*”-ийн 7-д “*Соёлын төвийн номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музей /орон нутаг сурталчлах танхим/-н ажилтныг сумын Засаг даргын тамгын газартай зөвшилцөн Соёлын төвийн эрхлэгч томилж, чөлөөлнө*” гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоож, зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргах байх албан шаардлага өгөх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримтыг мөрдөөгүй, хүчингүй болсон анхан шатны баримтаар санхүүгийн тайлан бэлтгэсэн. Нярав агуулахын бүртгэл хөтлөөгүй, бүртгэл тайлагнал хангалтгүй ажилласан байна.

Өгсөн зөвлөмж: Няраваар анхан шатны баримт хөтлөлтийг бүрэн гүйцэтгүүлэн, хяналтыг сайжруулан ажиллаж хэвших.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 1103 кодтой ширээ /малайз/, 1106 кодтой Зөөлөвчтэй хар сандлын ашиглах хугацааг оруулаагүйгээс элэгдлийн зардлыг бодоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг сангийн сайдын элэгдэл тооцох журмыг баримтлан, үнэн зөв тооцоолж ажиллах

3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал /210801/, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал /210405/, бараа ажил үйлчилгээний бусад зардал /210901/-аас бичиг хэргийн материал, аж ахуйн материал, материалын худалдан авалтыг хийсэн.

Өгсөн зөвлөмж: Зардлын батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулан, худалдан авалтыг хийж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэсэн.	1	9,948.1	-	-	1	9,948.1	1	9,948.1	-	-	-	-
Дүн	1	9,948.1	-	-	1	9,948.1	1	9,948.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны	Тоо	Дүн
Соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогчийг ТҮ-8 цалингийн ангиллаар /797676 төгрөг/ улиралд 40 хувиар цалинжуулж, хэмнэгдсэн цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан.	1	957.2	-	-	1	957.2	-	-	-	-	-	-
Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримтыг мөрдөөгүй, хүчингүй болсон анхан шатны баримтаар санхүүгийн тайлан бэлтгэсэн. Агуулахын бүртгэл хөтлөөгүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал /210801/, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал /210405/, бараа ажил үйлчилгээний бусад зардал /210901/-аас бичиг хэргийн материал, аж ахуйн материал, материалын худалдан авалтыг жийсэн.	1	648.6	-	-	-	-	1	648.6	-	-	-	-
1103 кодтой ширээ /малайз/, 1106 кодтой Зөөлөвчтэй хар сандлын ашиглах хугацааг оруулаагүйгээс элэгдлийн зардлыг бодоогүй.	1	209.8	-	-	-	-	1	209.8	-	-	-	-
Дүн	4	1,815.6	-	-	1	957.2	3	858.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Байхгүй.								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зерчил								
Байхгүй.								
Дүн								
Нийт дүн								